




БАТЛАВ.  
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА

Э. ТҮВШИНЧУЛУУН



БАТЛАВ.  
НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН  
ГАЗРЫН ДАРГА

Б.АМАРТҮВШИН

## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН СУРАГЧДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ “ТОГ ТОГ” БҮЖГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

**Зорилго:** Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд эрчим хүчийг зүй зохистой хэрэглэх, амьдралын зөв дадал хэвшлийг суулгах замаар хэмнэх хандлагыг бий болгох, эрчим хүч хэмнэх энгийн аргуудаас суралцах сонирхлыг төрүүлэх, аливаад багаар ажиллах чадварт суралцуулахад оршино.

**Зохион байгуулагч:** Эрчим хүчний зохицуулах хороо, Нийслэлийн Боловсролын газар

**Дэмжигч байгууллага:** АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID)-ийн санхүүжилттэй “Монголын эрчим хүчний засаглал” хөтөлбөр, АНУ-ын Элчин сайдын яам

**Хугацаа:** Ерөнхий боловсролын сургуулиудын дунд 2024 оны 10 дугаар сарын 07-оос 10 дугаар сарын 31-ний өдрийн хооронд зохион байгуулна.

### Уралдаанд хэрхэн оролцох вэ?

- Сургууль тус бүр эрчим хүчийг зүй зохистой хэрэглэх, хэмнэх хандлагыг хэвшүүлэхэд чиглэсэн “Тог тог” дуун дээр зохион байгуулагчдын бэлдсэн бүжгийн рийл дээрх хөдөлгөөнийг оруулж, нэмж баяжуулан анги хамт олноороо бүжиглэж, гэр бүл, найз нөхдөө эрчим хүчний хэмнэлтэд уриалж буй 2 минут хүртэл урттай, рийл хэлбэртэй видеог бэлтгэж, Фэйсбүүкт #TogooTokhiruuliy хаштагтайгаар, public буюу олон нийтэд нээлттэй тохиргоотойгоор @erc.gov.mn, @USAIDMongolia, @Нийслэлийн Боловсролын газар Фэйсбүүк, пэйж хуудсуудыг меншион хийж 2024 оны 10 дугаар сарын 14-өөс 25-ны өдрүүдэд оруулна.

- Эрчим хүчийг зүй зохистой хэрэглэх, хэмнэх хандлагыг хэвшүүлэхэд чиглэсэн уриа үгийг сургууль бүр бэлтгэж, рийл хэлбэртэй видеоны төгсгөлд оруулсан байна.

- Сургууль дээрээ эрчим хүч хэмнэх бүтээлч үйл ажиллагаа зохион байгуулж, түүний талаар Фэйсбүүкт #TogooTokhiruuliy хаштагтайгаар, public буюу олон нийтэд нээлттэй тохиргоотойгоор @erc.gov.mn, @USAIDMongolia, @Нийслэлийн Боловсролын газар Фэйсбүүк, пэйж хуудсуудыг меншион хийж оруулна.

- Дээрх хоёр постны хандалтын мэдээг Нийслэлийн боловсролын газарт 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 16:00 цагаас өмнө ирүүлнэ.

### **Хоёр. Дүгнэх журам**

- Уралдааны үр дүнгийн 80%-ийг 80 хүртэл оноогоор дүгнэх бөгөөд үүнээс бүжгийн рийлийн сошиал хандалтын views (25%) 20 оноо, like (25%) 20 оноо, share (25%) 20 оноо, comment (25%) 20 оноо хүртэл үнэлгээгээр тус тус дүгнэнэ.

- Үлдсэн 20% буюу 20 хүртэл оноог сургууль дээр зохион байгуулсан ажлын үр дүн, бүтээлч байдлыг харгалзан шүүгчдийн өгөх үнэлгээгээр дүгнэнэ.

### **Гурав. Шагнал урамшуулал**

Багийн үзүүлэлт тус бүрийн дүнг нэгтгэж их онооны системээр дүгнэж шалгаруулна.

Шалгаруулах байр	Шагналын тоо	Шагнал урамшуулал
Тэргүүн байр	1	Өргөмжлөл, 1 сая төгрөг
Дэд байр	1	Өргөмжлөл, 500 мянган төгрөг
Гуравдугаар байр	1	Өргөмжлөл, 300 мянган төгрөг

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН СУРАГЧДЫН ДУНД ЗОХИОН  
БАЙГУУЛАХ “ТОГ ТОГ” БҮЖГИЙН УРАЛДААНЫГ ДҮГНЭХ ХУГАЦААГ СУНГАЖ  
БАЙНА.

2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

**Уралдаанд хэрхэн оролцох тухай:**

-Сургууль бүр “Тог тог” дуун дээр  
(<https://www.youtube.com/watch?v=I9iYliVBKuA>) зохион байгуулагчдын бэлдсэн  
бүжгийн рийл дээрх  
(<https://www.facebook.com/USAIDMongolia/videos/1292843875158389>  
<https://www.facebook.com/USAIDMongolia/videos/505302129083256>) бүжгийн  
хөдөлгөөнийг оруулж, нэмэн баяжуулж анги хамт олноороо бүжиглэж (хүний тоо хэд  
байхыг сургуулиуд өөрсдөө шийднэ. Жишээ нь:  
<https://www.facebook.com/USAIDMongolia/videos/913398543993644>), бусдыгаа эрчим  
хүчний хэмнэлтэд уриалж буй 2 минут хүртэл урттай видеог бэлтгэж, Фэйсбүүкт  
**#togootokhiruuliy хаштагтайгаар “Бид тог, дулаанаа зөв хэрэглэж, зөндөө  
хэмнэх уриалгад нэгдэж байна. Та ч бас нэгдээрэй”** гэсэн тайлбартайгаар public  
буюу олон нийтэд нээлттэй тохиргоотойгоор **2024 оны 10 дугаар сарын 28-аас  
2024 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийг дүүстэл** хугацааны хооронд нийгмийн  
сүлжээнд оруулна. Уралдааныг тухайн бичлэгийг үзсэн үзэлтийн тоогоор дүгнэх тул  
сургуулиудыг видеогоо аль болох эрт оруулахыг уриалж байна.

- Видео постныхоо үзэлтийн тоог 2024 оны 11 дүгээр сарын 17-ны 18:00 цагаас  
өмнө [info@erc.gov.mn](mailto:info@erc.gov.mn) болон [Info.Mongolia@abtglobal.com](mailto:Info.Mongolia@abtglobal.com) мэйл хаягууд руу  
скрийн шот хийж ирүүлнэ. Зөвхөн үзэлтийн тоогоо ирүүлсэн сургуулиудыг  
шалгаруулалтад оруулна.

**Дүгнэж урамшуулах тухай:**

Видеоны үзэлтийн тоогоор тэргүүлсэн эхний гурван сургуулийг дараах  
байдлаар мөнгөн шагналаар шагнаана.

Шалгаруулах байр	Шагналын тоо	Шагнал урамшуулал
Тэргүүн байр	1	Өргөмжлөл, 1 сая төгрөг
Дэд байр	1	Өргөмжлөл, 500 мянган төгрөг
Гуравдугаар байр	1	Өргөмжлөл, 300 мянган төгрөг

Жич: 2024 оны 09 дүгээр сарын 30-нд гарсан удирдамжийн “Уралдаанд хэрхэн  
оролцох вэ?” болон “Дүгнэх журам”-ыг хүчингүй болсонд тооцно.